



Л.АЛТАНСҮХ
Шүүхийн
шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн
Эрүүгийн ял
эдлүүлэх эрх
зүйн тэнхимийн
эрхлэгч, дэд
хурандаа

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯЛТНЫ ДУНДААС ГАРЧ БУЙ ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Илтгэлийн хураангуй. Энэ илтгэлээр хорих байгууллагад гарч байгаа зөрчлийн бүтцэд дүгнэлт хийж, шалтгаан нөхцлийг тодруулах чиглэлээр хийсэн судалгааны үр дүнгээ танилцуулж, зарим дүгнэлт, саналыг дэвшүүлнэ.

Түлхүүр үг: ялтны зөрчил, сахилгын шийтгэл, шалтгаан нөхцөл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд мөрдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 2002 оны 09-р сард батлагдсанаас хойш 2003, 2005, 2007, 2009, 2010, 2013 онуудад нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд 11 жилийн хугацаанд хуульд нийцүүлэн 140 гаруй эрх зүйн акт, заавар журмыг тус тус боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд төвлөрсөн хорих анги 25, үүнээс гяндан нэг, онцгой дэглэмтэй хорих анги нэг, чанга дэглэмтэй хорих анги 11, жирийн дэглэмтэй хорих анги 11. Баривчлах ял


эдлүүлэх анги 1, баривчлах ял эдлүүлэх байр 13. Цагдан хорих анги 1, баривчлах цагдан хорих байр 25, цагдан хорих хэсэг 2. Гадаадын иргэдийг албадан саатуулах байр нэг ажиллаж хуульд заасан чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж, тэдгээрт 6500 орчим ялтан ял эдлэж байна.

Хорих байгууллага нь баривчлах, хорих ялыг албадан эдлүүлэх ялтны аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ялтны дундаас гарч буй зорчлоос урьдчилан сэргийлэх талаар торол бүрийн арга хэмжээг зохион байгуулж байгаа боловч зорчил тогтвортой буурахгүй, шинэ төрлийн зорчил гарах, цаашид өсөх хандлагатай байна. Түүнчлэн зарим ялтанууд хууль, олон нийтийн эрх ашгаас хувь хүн, хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийг илүүд үзэн илтэд хууль зорчих, хууль зорчихийг бусдад уриалах зэргээр дураараа авирлах явдал түгээмэл болох хандлагатай болж байгаа нь зорчлийн аюултай шинэсийн илрэл төдийгүй цаашидаа улам хүндрэх дохио сануулга гэж үзэж зорчилтэй шинэслэх ухааны үндэслэлтэйгээр тэмцэхгүй бол сайжрах төлөвгүй байна.

Хорих ангид ялтны дундаас гарч буй зөрчилгэж юу вэ?

2002 онд батлагдан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, 2013 онд батлагдсан “Хорих ангийн дотоод журам”-д : “Ялтан хууль тогтоомж,



түүний дагуу батлагдсан заавар, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд хорих ангийн даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулна.” гэж заасан байна. Энэхүү заалтаас үзэхэд ялтан нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан заавар, журам зөрчсөнийг хорих ангийн албан хаагч илрүүлэн баримтжуулж, эрх бүхий албан тушаалтан шалган, гэмт хэргийн шинжгүй бол ялтны зөрчил байхаар хуульчилсан байна.

Гэмт хэргийн шинжгүй гэдэг нь Монгол улсын Эрүүгийн хуулийн 16-р зүйлийн 16.2-д зааснаар “... Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй...” гэсэн заалт нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн ялгааг хуульчилсан хэлбэр юм.

Хорих ангид ялтны дундаас гарч байгаа зөрчлийг дараах байдлаар ангилан үзэж байна. Үүнд:

- Ажил хийхээс зайлсхийх
- Ажлын талбай, хорих зонноос дур мэдэн явсан
- Бусдыг дарамталсан, эд зүйл булаасан

➤ Бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулсан

➤ А р х и , согтууруулах ундаа хэрэглэсэн

➤ Хулгай хийсэн

➤ Х о р и о т о й тоглоом тоглосон

➤ Албан хаагчийн

хууль ёсны шаардлага эсэргүүцсэн

➤ Гар утас ашигласан

➤ бусад

Ялтны дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтнаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх үүднээс хяналт, харуул хамгаалалтыг тасралтгүй тавьж байгаа боловч сүүлийн 5 жилд ялтны гаргасан зөрчилийн тоо эрс нэмэгдэж өмнөх 5 жилтэй харьцуулахад 59 хувиар өссөн дүнтэй байна.

2012 оны судалгаанд ялтны дундаас гаргасан 1956 зөрчил байгаагаас гар утас ашигласан 1304, архи уусан 179, албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн 92, хориотой тоглоом тоглосон 31, бусдыг дарамталсан, эд зүйл булаасан 30, бусдын биед гэмтэл учруулсан 29, ажил хийхээс зайлсхийсэн 8, бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулсан 4, ажлын талбай, хорих зонноос дур мэдэн явсан 2, бусад зөрчил 277 байна. Эдгээр зөрчлийг хувьчлан авч үзвэл гар утас ашигласан зөрчил 66,6хувь, архи уусан 9,1 хувь, албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага эсэргүүцсэн 4,7 хувь байгаа ба эдгээр нь нийт зөрчлийн 80,4 хувийг эзэлж байна.



2012 оны зөрчлийн судалгааг 2013 оны 10-р сарын зөрчлийн судалгаатай харьцуулахад гар утас ашигласан зөрчил 8,2 хувь, албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн 0,3 хувиар тус тус өсч, архи уусан зөрчил 3,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэхдээ энэ харьцуулсан судалгаа 2012 оны бүтэн жилийн судалгааг 2013 оны эхний 10 сарын байдалтай харьцуулсан гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

Судалгаанаас харахад хорих ангид ялтны дундаас үйлдэж буй зөрчил тододолон буурахгүй өсөх хандлага ажиглагдаж байна. Нийгэм, техник технологи хөгжихийн хэрээр гарч байгаа зөрчлийн шинж байдал, бүтэц өөрчлөгдөх боллоо. Сүүлийн жилүүдэд хорих ангид гарч буй зөрчлийг өнгөөр нь авч үзвэл гар утас ашиглах, архи, согтууруулах ундаа хэрэглэх, албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага эсэргүүцсэн зөрчил өссөн байна.

Эдгээр зөрчлийн талаар судалгаа явуулахад хорих ангийн нийгмийн ажилтнууд хорих ангийн дотоод журамд заасан хугацаанд утсаар яриулдаггүй, зарим тохиолдолд сардаа нэг удаа

утсаар яриулдаг, ар гэртээгээ утсаар ярих нөхцөл боломж муу учраас гар утас ашиглаж зөрчил гаргадаг, архи, согтууруулах ундаа хэрэглэх зөрчил нь ихэвчлэн гадуур гэрээ, хэсэгт ажиллаж байгаа ялтнууд хэрэглэдэг, албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага эсэргүүцсэн зөрчил нь албан хаагчид ялтнуудтай харилцахдаа ялтныг доромжлон дуудах, үл ойлголцох харьцаанаас болж зөрчил их гарч байна.

Ялтан нь хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэглэм, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд хорих ангийн даргын шийдвэрээр ээлжийн бус ажил хийлгэх, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, сахилгын байранд хорих, тухайн улирал, эсхүл жилд олгосон шагналын хоногийг хасах гэсэн 4 төрлийн сахилгын шийтгэл оногдуулахаар хуульчилсан байдаг.

2012 оны байдлаар хорих ангийн дотоод журам, цагийн хуваарийг зөрчиж, хорих анги, албаны даргын тушаалаар сахилгын хорих байранд хорихоор 619, ээлжийн бус ажил хийлгэхээр 915, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөхөөр 164, шагналын хоног хасахаар 258, нийт 1956 ялтанд сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Ялтнуудад авагдсан арга хэмжээг





хувьчилвал: сахилгын хорих байранд хорих 31,6 хувь, ээлжийн бус ажил хийлгэх 46,7 хувь, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх 8,3 хувь, шагналын хоног хасах 13,1 хувийг эзэлж байна.

2013 оны эхний 10 сарын байдлаар ялтны гаргасан зөрчилд оногдуулсан арга хэмжээг харьцуулахад өөрчлөлт бага гарч байна.

Дүгнэлт

1.Хорих байгууллагад ял эдэлж буй ялтны дундаас гарч буй зөрчилийн бүтэц өөрчлөгдөж байна. Тухайлбал 2000 оны үеийн зөрчил өнөөдрийн зөрчилийн хооронд өөрчлөгдсөн.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зөрчилтэй тэмцэж ирсэн өнөөгийн аргаа өөрчлөх шаардлагатай байна. Учир судалгаагаар зөрчил үйлдэж байгаа ялтны нас, хэргийн өнгө, дэглэм, хорих ангийн онцлого, гэх мэт олон төрлийн шалтгаанд кримнологи судалгаа шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг илрүүлэн түүнд тулгуурлан нэгдсэн бодлоготой тэмцэх

3.Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр батлагдах ял эдлүүлэх ажиллагааны тухай хууль тогтоомжийн хүрээнд одоогийн мөрдөж байгаа хуулийг нийцүүлэн өөрчлөх, гадаадын зарим орны туршлагыг судлах

Санал

1.Хорих байгууллагын гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагааны уламжлалыг судлан, орчин цагын нөхцөл байдалд зохицуулан зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэтийн болон ойрын,

өдөр тутмын хэлбэрээр төлөвлөн сайтар боловсруулан хэрэгжүүлэх

2.Шинээр батлагдан гарах ял эдлүүлэх ажиллагааны тухай хуулийн төсөлд:

- ШШГТМУ хуулийн 127-р зүйлийн 127.1.2 заасан “ээлжийн бус ажил хийлгэх” гэсэн сахилгын шийтгэлийг хасах
- ШШГТХуулийн 127-р зүйлийн 127.6-д заасан “Жилд хоёроос дээш удаа сахилгын шийтгэл хүлээсэн ялтан дахин ноцтой зөрчил гаргавал хорих ял эдлүүлэх дэглэмийг чангаруулах тухай саналыг хорих ангийн дарга прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ” гэсэн зүйлээс “ноцтой” гэсэн үгийг хасах
- Шинээр сахилгын шийтгэлийн төрөл болгож “ялтны эргэлт, уулзалтыг тодорхой хугацаагаар хязгаарлах”
- Зөрчлийг хянан шийдвэрлэх процессын ажиллагааг журамлах